



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СТАТИСТИКИЙН ЧАНАРЫН ТАЙЛАН

/Дундаж цалин хөлсний статистик/

Улаанбаатар хот
2018 он

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яам
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ЦХБ	Цалин хөлсний бүтэц
АЭЗ	Ажил эрхлэлтийн зардал
БЦИ	Бодит цалингийн индекс

Агуулга

1	Нийтлэг үндэслэл.....	4
2	Ойлголт, тодорхойлолт	8
3	Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт	10
3.1	Үнэн бодит, найдвартай байдал.....	10
3.2	Цаг хугацаандаа байх, шуурхай байх	11
3.3	Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдал	12
3.4	Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал.....	13
3.5	Нийцтэй, харьцуулах боломжтой байдал	13
4	Нууцлалыг хангасан байдал	14

1 Нийтлэг үндэслэл

Засгийн газрын байгууллага болон бусад байгууллагын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлого, хөтөлбөрийг дэмжих, дэлхийн хүн амын хөдөлмөр эрхлэлт ямар байгааг үнэлэх, хянах зорилгоор Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас “Хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр үзүүлэлт”-ийг 1999 онд анх тодорхойлон гаргасан бөгөөд 2016 онд шинэчилсэн (KILM 9th edition). Хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр үзүүлэлтэд дундаж цалингийн статистиктэй холбогдох цалин хөлс болон нөхөн олговрын зардал зэрэг үзүүлэлт орно. Сарын дундаж цалинг нэрлэсэн болон бодит цалин гэсэн хоёр аргачлалаар тооцон гаргаж байна.

Дэлхийн улс орнууд цалингийн статистикийн мэдээллийг захиргааны мэдээлэл, албан ёсны мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан түүвэр судалгаа болон ажиллах хүчний судалгаа, өрхөд суурилсан түүвэр судалгаа гэсэн эх үүсвэрүүдээс гаргаж, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллээ тархааж байна.

Үндэсний статистикийн газар (хуучин нэрээр) (ҮСГ) нь дундаж цалингийн статистикийн мэдээллийг анх 1940-1992 онд Улс ардын аж ахуйн ажилчин, албан хаагчдын тоо, цалингийн фондоос, 1993 онд аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-д суурилсан түүвэр судалгааны үр дүнгээр буюу ААНБ-ын ажиллагчдын нэг цагт ногдох цалин, хөдөлмөрийн хөлсний судалгаанаас, 1994-2003 онд ААНБ-ын ажиллагчдын цалингийн түүвэр судалгаа, 2003-2013 онд ААНБ-ын ажиллагчдын тоо, дундаж цалин, ажлын цагийн үргэлжлэл, ажиллах хүчний зардлын бүрэлдэхүүний судалгаа зэрэг олон эх үүсвэрээр тодорхойлж байсан.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1.2-ын “ё”-д заасны дагуу дундаж цалин, орлогын албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь 2000 оны 4 дүгээр улирлаас эхлэн тогтмол тооцож байна.

Мөн ҮСХ нь нэг удаагийн түүвэр судалгааг зохион байгуулж явуулдаг бөгөөд цалин хөлсний бүтэц (ЦХБ)-ийн туршилтын судалгааг 2009 онд НХХЯ-тай хамтран

зохион байгуулан явуулснаар цалин хөлсний бүтцийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргасан.

Түүнчлэн ажил эрхлэлтийн зардал (АЭЗ)-ын туршилтын судалгааг 2012-2013 онд зохион байгуулж явуулснаар ажил олгогчоос ажиллагчид өгч буй цалингийн болон цалингийн бус зардлыг дэлгэрэнгүй судалсан.

Төрийн мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бий болгох, түүний ашиглалтыг сайжруулах, мэдээллийн давхардлыг арилгах, мэдээлэгчид очиж буй дарамтыг бууруулах зэрэг хэрэгцээ, шаардлагын дагуу ҮСХ, Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) хамтран нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн НД-7, НД-8 маягтыг шинэчилж, албан ёсны статистикийн 6 маягт, маягт нөхөх зааврыг шинээр тус тус боловсруулсан. Үүний дагуу ҮСХ нь 2014 оноос эхлэн мэдээллийн эх үүсвэрийг өөрчилж, захиргааны мэдээлэл буюу Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн ажиллагчдын сарын дундаж цалинг тооцож байна.

ҮСХ нь ажиллагчдын сарын дундаж цалин хөлсний албан ёсны статистик мэдээллийг гаргахдаа Монгол Улсын хууль болон Олон Улсын конвенц, тогтоол, зөвлөмжийг дагаж мөрддөг. Үүнд:

- ОУХБ-ын “Хөдөлмөрийн статистикийн тухай” 1985 оны 160, 170 дугаар Конвенц
- Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1.2-ын “ё”-д заасны дагуу дундаж цалин, орлогын албан ёсны статистик мэдээллийг тооцох.
- Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 7-д Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, дундаж цалингийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийсний үндсэн дээр улсын хэмжээнд тархаах, ажиллагчдын амьжиргааны зарим үзүүлэлт, худалдан авах чадварын өөрчлөлтийн хандлагыг тодорхойлох, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон хэрэглэгчдийг холбогдох мэдээллээр хангахад цалин хөлсний статистикийн судалгаа чиглэгдсэн. Дундаж цалингийн статистикийн мэдээллийг тооцон гаргаснаар олон улсын түвшинд харьцуулах боломжийг бүрдүүлж байна.

Ажиллагчдын цалин хөлс нэмэгдэхэд өрхийн орлого тэр хэмжээгээр нэмэгдэж ажилгүйдэл тодорхой хэмжээгээр буурна. Тиймээс цалин хөлсний бодлого нь аливаа улс орны нийгмийн баталгааг илэрхийлэх бодлогын салшгүй нэг хэсэг байж, хөгжлийн нэгэн чухал үзүүлэлт болж байдаг.

Дундаж цалин хөлсний мэдээллийг дараах задаргаагаар гаргаж, улирал, жилийн давтамжтайгаар тогтмол тооцон, нийтэд тархааж байна.

Үүнд:

- Монгол улсын засаг захиргааны нэгжээр
- Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын тооны бүлгээр
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Үндэсний ажил мэргэжлийн ангиллаар
- Аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр
- Аж ахуйн нэгж байгууллагын өмчийн хэлбэрээр
- Цалин хөлсний бүлгээр

Хамрах хүрээ

Ажиллагчдын сарын дундаж цалин хөлсний мэдээлэл нь дараах хүрээг хамарна.

Үүнд:

1. Газарзүйн байршил: Улс, бүс, аймаг, нийслэл
2. Хүн ам зүйн байдал: Хүйс
3. Хугацаа: Улирал, жил
4. Ангилал: Ажил, мэргэжлийн ангиллын үндсэн 10 бүлэг, Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын үндсэн 21 салбар, 88 дэд салбар, хариуцлагын болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага
5. Үйл ажиллагаа нь түр болон бүрэн зогссон, татан буугдсан зэрэг идэвхгүй байгаа ААНБ хамаарахгүй
6. Сайн дураар даатгуулагчдын мэдээлэл хамаарахгүй.

Ангилал, стандарт

Монгол Улсад ажиллагчдын цалин хөлсний үзүүлэлтийг хэмжих дараах үндсэн аргачлал, ангилал болон кодыг ашиглаж байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргааны ангилал, код
- Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ISCO-08)
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)
- ҮСХ-ны даргын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/173 тоот тушаалаар батлагдсан Бодит цалингийн индексийг тооцох аргачлал
- ҮСХ-ны даргын 2012 оны 08 дугаар сарын 14-ний 1/96 тоот тушаалаар батлагдсан Ажил эрхлэлтийн зардлын индекс тооцох аргачлал

Арга зүй

Тодорхой хэмжээний цалин хөлсийг хэд хэдэн ажиллагчид авдаг, өөрөөр хэлбэл цалин хөлсний хэмжээ давтагдаж байдаг учраас ажиллагчдын сарын дундаж цалин хөлс нь тайлант хугацаан дахь нийт цалингийн хэмжээг тухайн хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоонд жигнэж тооцсон үзүүлэлт юм. Энд

цалин хөлс нь бодогдсон цалин буюу нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар суутгахаас өмнөх цалин хөлс юм.

Медиан цалин

НДЕГ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тухайн улирал/жилд хамрагдсан нийт ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр жагсаахад түүний төв буюу хоёр талыг тэнцүү хэсэгт хувааж буй ажилтны цалингаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл медиан цалин гэдэг нь нийт цалинтай ажиллагчдын авч буй голч цалингийн хэмжээ юм.

Бодит цалингийн индекс

Бодит цалингийн индекс (БЦИ) нь ажиллагчдын орлогын ерөнхий түвшингийн өөрчлөлтийг харуулах үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтийг нийгэм, эдийн засгийн бодлогын хяналт, хэрэгжилт, ялангуяа хөдөлмөрийн нөөцийн талаар бодлого төлөвлөлт, ашиглалт, цалингийн хэмжээг тогтоох, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зардал зэрэг хөдөлмөр эрхлэлтийн холбогдох асуудлыг тодорхойлох, боловсруулахад суурь мэдээлэл болгон ашиглана. Энэхүү үзүүлэлт нь бодит цалингийн өөрчлөлтийг салбараар, ажил мэргэжлийн ангиллаар, байгууллагын төрлөөр харуулна.

БЦИ нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас зөвлөмж болгосон хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр 20 үзүүлэлтийн нэг бөгөөд бодит цалин нь тухайн үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэсэн ажил, орлогын түвшинг илэрхийлж, ажиллагчдын худалдан авах чадварыг харуулах гол үзүүлэлт юм.

2 Ойлголт, тодорхойлолт

Дундаж цалин: Тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого: Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн олговор болон бусад олговор, хоол, унаа, ажилдаа ирж, очихтой холбоотойгоор зайлшгүй гарах зардлыг бүрэн болон хэсэгчлэн нөхөх зорилготой мөнгөн төлбөрүүдээс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Нийгмийн Даатгалын тухай хуулийн 32-р зүйлийн 1-ийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан орлого байна.

Үндсэн цалин: Ажиллагчдад олгосон цалин хөлс байна. Энд бүтэн цагаар ажиллагчдын үндсэн цалин бүрэн болон бүрэн бус цагаар ажиллагчдын хөдөлмөрийн хөлс орно.

Нэмэгдэл: Албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл, докторын зэргийн нэмэгдэл, ажилласан хугацааны нэмэгдэл, удаан жилийн нэмэгдэл, цэргийн цолны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, ур чадварыг нэмэгдэл, бусад нэмэгдэл орно.

Нэмэгдэл хөлс: Ажлын үр дүнгээр олгож буй нэмэгдэл хөлс, үндсэн ажлынхаа зэрэгцээ бусад мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласны, эзгүй байгаа ажилтны үүргийг гүйцэтгэсэн ажлын, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн ажлын, нийтээр амрах болон баяр ёслолын өдөр ажилласны, илүү цагаар болон, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс орно.

Шагнал урамшуулал: Улирал, жилийн эцсийн ажлын үр дүнгээр болон онцгой чухал буюу онц албан даалгавар биелүүлсний төлөө олгох мөнгөн урамшуулал, ашиг хуваарилалтын шагнал, амралт болон шагнал урамшуулалтай холбоотой бусад нэмэгдэл төлбөрүүд, олгосон эд зүйл болон үнэ бүхий зүйлийн шагнал, урамшуулал орно.

Ажиллаагүй цагийн олговор: Ээлжийн амралтын олговор, цалинтай чөлөө, сул зогсолтын үеийн олговор гэх мэт орно.

Хууль тогтоомжид заасан бусад олговор: Монгол Улсын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу олгох бусад олговор орно.

Медиан цалин: Ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм.

Нэрлэсэн цалин: Хэрэглээний үнийн индексээр засварлагдаагүй, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлдэггүй бөгөөд татвар суутгал хасагдаагүй цалин, хөлс юм.

Нэрлэсэн цалингийн индекс: Тайлант болон суурь хугацаа (жил, улирлын)-ны нэрлэсэн дундаж цалин хөлсний харьцаа юм.

Бодит цалин: Нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Бодит цалингийн индекс: Нэрлэсэн цалингийн индексийг, тайлант оны хэрэглээний үнийн индекст харьцуулж, 100-гаар үржүүлж тооцно.

3 Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын олон талт ойлголттой холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар нь хэрэглэгчдийн үнэлэх үнэлэмж, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага болон мэдээллийн чанар, ач холбогдлоор тодорхойлогдож байна. Дундаж цалингийн статистикийн мэдээллийг ҮСХ-ны чанарын бодлогын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлж байна. Үүнд:

3.1 Үнэн бодит, найдвартай байдал

Дундаж цалин нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Шимтгэл төлсөн нийт ажиллагчид/даатгуулагчид, тэдгээрийн сард ногдох цалин хөлсийг 21 аймаг, нийслэл, бүсээр, ААНБ-ыг ажиллагчдын тоогоор, ажил мэргэжлийн үндсэн 10 ангилал болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хариуцлагын болон өмчийн хэлбэрээр ангилан ялгаж, тус

бүрийн хувьд ажиллагчдын сарын дундаж цалин хөлсийг тооцдог. Мөн шимтгэл төлсөн ААНБ-ын ажиллагчдын цалин хөлсийг 240.0 мянган төгрөг хүртэл, 240.0-300.0 мянга, 300.0-500.0 мянга, 500.0-700.0 мянга, 700.0-900.0 мянга, 900.0-1100.0 мянга, 1100.0-1500.0 мянга, 1500.0 мянган төгрөг, түүнээс дээш гэсэн цалин хөлсний 8 бүлгээр, дүнд эзлэх хувиар гаргаж байна.

НДЕГ нь дундаж цалин хөлстэй холбогдох тоо, мэдээллийг ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 31-ний өдрийн 1/158 тоот тушаалаар батлагдсан албан ёсны 7 маягтын дагуу гарган ирүүлж байна. ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын нийгмийн статистикийн албаны ахлах болон салбар хариуцсан шинжээч НДЕГ-т очиж тогтоосон аргачлалын дагуу, үнэн бодитой тооцож байгаа эсэх талаар хяналт тавьж ажилладаг.

3.2 Цаг хугацаандаа байх, шуурхай байх

- Шимтгэл төлөгч ААНБ-ууд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сум/дүүргийн нийгмийн даатгалын алба/хэлтэс рүү цаасаар болон цахимаар хүргүүлнэ.
- Сум/дүүргийн нийгмийн даатгалын алба/хэлтсээс тайланг цахим хэлбэрээр 2013 оны нийслэл/аймгийн нийгмийн даатгалын газар/хэлтэст хүргүүлнэ.
- Нийслэл/аймгийн нийгмийн даатгалын газар/хэлтсээс Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.
- Нийгмийн даатгалын ерөнхий газраас ҮСХ-ны даргын 1/158 тоот тушаалаар батлагдсан 7 маягтын дагуу тухайн жилийн 1, 2, 3, 4 дүгээр улирал буюу 2, 5, 8, 12 дугаар сарын 28-нд ҮСХ-нд ирүүлнэ.
- Мэдээллийг хүлээн авах, хянах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСХ-нд, харин зааврын дагуу сангаас тооцоолох, ҮСХ-нд дамжуулах ажлыг НДЕГ хариуцаж байна.

- Мэдээллийн үр дүнг улирал, жилээр ҮСХ-ноос тогтоосон мэдээ, тайлан тархаах графикт хугацааны дагуу хэвлэмэл болон электрон хэлбэрээр хэрэглэгчдэд тархааж байна.

3.3 Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдал

Нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотойгоор цалин хөлсний мэдээллийг ашиглах эрэлт, хэрэгцээ, сонирхол нэмэгдэж өргөн хүрээг хамарч байна.

Үндэсний статистикийн хороо нь дундаж цалингийн статистикийн мэдээллийг Монгол Улсад албан ёсоор ажил, хөдөлмөр эрхэлдэг иргэний дундаж орлого, амьжиргааны байдал болон бусад үзүүлэлтүүдийг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн нэгдсэн аргачлалаар тодорхойлж, бодлого боловсруулагч, судлаач, шинжээч нарыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор дундаж цалингийн статистикийн мэдээллийн үр дүнг улирал, жилээр тархаан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хороо нь ажиллагчдын сарын дундаж цалинг 2000-2013 онд аж ахуйн нэгж, аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан түүвэр судалгааны үр дүнгээр тооцож байсан. Харин 2014 оноос эхлэн мэдээллийн эх үүсвэрийг өөрчилж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн тооцож байна. Ингэснээр өмнө гаргаж байсан үзүүлэлтүүд дээр нэмж сарын дундаж цалинг ААНБ-ын ажиллагчдын тоогоор нь ангилсан 5 бүлгээр, цалин хөлсний 9 бүлгээр, дүнд эзлэх хувиар тархаах боломжтой болсон.

Мөн 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн медиан цалинг тооцон тархааж байна.

- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг
 - Улсын дундаж, бүс, аймаг, нийслэл, хүйсээр
 - Ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр
 - Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
 - Ажил мэргэжлийн ангилал, хүйсээр

- Бодит цалингийн индекс, 2010=100%, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Байгууллагын хариуцлагын хэлбэр, хүйсээр
- Байгууллагын өмчийн хэлбэр, хүйсээр
- Ажиллагчдын цалин хөлсний бүлгээр гаргаж байна.

✓ Медиан цалин

3.4 Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

Үндэсний статистикийн хорооны хувьд бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчдэд нээлттэй, ил тод байдаг. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдлыг хангахдаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг.

Хэрэглэгчдэд дундаж цалингийн статистикийн мэдээллийг инфографик, танилцуулга, хүснэгт хэлбэрээр тархахаас гадна Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болох www.1212.mn вэб сайтад тавигддаг. Уг вэб сайтаас мэдээллийн арга, аргачлал, агуулга, танилцуулга, хүснэгтийг татаж авч ашиглах боломжтой. Мөн вэб сайтад байрших мета мэдээллийн сангаас дундаж цалингийн статистикийн мета мэдээллийг харж болно.

Нөгөө талаас хэрэглэгчдэд хүртээмжтэй, орон зай, цаг хугацаанаас хамаарахгүйгээр хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлсэн www.1212.mn вэб сайтын үзүүлэлтүүдийг iPhone, iPad, Android төхөөрөмж ашиглан үзэх боломжтой ezStat аппликейшн, iPhone, iPad, Android төхөөрөмжүүдэд зориулсан статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших боломжтой Monstat аппликейшнийг ашиглан тархааж байна.

3.5 Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа үзүүлэлтүүд нь цаг хугацаа, орон зай, арга зүйн хувьд харьцуулагдахуйц байдаг. Цаг хугацааны хувьд

харьцуулагдахуйц байдал нь динамик мэдээллийн уртаар тооцогдохоос гадна хэрэглэгч харьцуулалт хийхдээ мэдээллийн давтамж (улирал, жил)-ийг харгалзан ижил цаг хугацааг харьцуулах, орон зайн хувьд үндэсний, бүс нутгийн, аймаг орон нутгийн гэх зэргээр засаг захиргааны нэгжээр харьцуулагдахуйц байх шаардлагатай байдаг.

Дундаж цалингийн статистикийн мэдээллийн хувьд мэдээллийн хэрэгцээ, ашиглалт, давтамж зэргээс шалтгаалан улирал, жил бүр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцдог бөгөөд улирал, жил бүр тоо мэдээллийг баяжуулж байна. Үүнд:

- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг
 - Улсын дундаж, бүс, аймаг, нийслэл, хүйсээр, улирлаар, жилээр
 - Ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр
 - Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
 - Ажил мэргэжлийн ангилал, хүйсээр
 - Бодит цалингийн индекс, 2010=100%, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
 - Байгууллагын хариуцлагын хэлбэр, хүйсээр
 - Байгууллагын өмчийн хэлбэр, хүйсээр
 - Ажиллагчдын цалин хөлсний бүлгээр гаргаж байна.

- ✓ Медиан цалин

4 Нууцлалыг хангасан байдал

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3-д "Албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно." гэсэн заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 6-д үндэслэн хуулийн этгээдийн мэдээллийн нууцыг чанд хадгалж, мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, салбарын түвшинд нэгдсэн дүн гаргах, статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглана.

ҮСХ нь НДЕГ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан ААНБ, ажиллагчид/даатгуулагчдын мэдээллийн нууцлалыг хангасан байдлаар ажиллагчдын тоо, сарын дундаж цалинг аймаг, бүс, нийслэл, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хариуцлагын болон өмчийн хэлбэрээр, ААНБ-ын ажиллагчдыг тоогоор нь 5 бүлэгт ангилж мэдээллийг авдаг.

Уг чанарын тайланд дурдагдсаны дагуу “дундаж цалингийн статистикийн мэдээлэл”-ийг ҮСХ-ноос улирал, жилийн давтамжтайгаар гаргаж, үр дүнг цаг хугацаандаа, үнэн зөв, шуурхай, ил тодоор хэрэглэгчдэд хүргэж байгаа болно.

Энэхүү чанарын тайлантай холбогдолтой асууж, тодруулах зүйлээ information@nso.mn цахим хаягаар болон 51-263966 утсаар лавлана уу.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ХҮН, АМ НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР